

Монгол Алтайн нурууны улсын тусгай хамгаалалттай газруудын хамгаалалтын захиргааны  
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Монгол Алтайн нурууны улсын тусгай хамгаалалттай газруудын хамгаалалтын захиргааны  
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: **БӨА-2023/171/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Өлгий хот  
2023 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: М.Хуанган  
Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn  
Аудитын менежер: Х.Женисбек  
Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn  
Ахлах аудитор: С.Нурлан  
Утас: 88403281 Цахим хаяг: nurlans@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

## **АГУУЛГА**

---

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	2
Асуудлыг онцолсон хэсэг .....	<b>Error! Bookmark not defined.</b>
Аудитын гол асуудал.....	<b>Error! Bookmark not defined.</b>
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	<b>Error! Bookmark not defined.</b>
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	14
4.1 Ерөнхий зүйл.....	14
4.2 Материаллаг байдал.....	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
4.5.1 Завсрын аудитын талаар.....	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	18

### **Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын стандарт

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ**



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,  
Утас/Факс: (976) 7042-2954  
E-mail: bayanulgi@audit.gov.mn

МОНГОЛ АЛТАЙН НУРУУНЫ УЛСЫН  
ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗРУУДЫН  
ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГААНЫ  
ДАРГА Ч.АСХАР ТАНАА

2023.02.20 № 112  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монгол Алтайн нурууны улсын тусгай хамгаалалттай газруудын хамгаалалтын захиргааны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Монгол Алтайн нурууны улсын тусгай хамгаалалттай газруудын хамгаалалтын захиргааны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Холбооны бүгд найрамдах Герман улсын олон улсын хамтын ажиллагааны GIZ төслийн шугамаар хүлээн авч ашиглаж байгаа Ланд-76 маркын авто машиныг холбогдох байгууллагуудаас төрийн өмчид бүртгэх талаар шийдвэр гараагүй байгаа учраас данс бүртгэлд тусгаагүй байна.

**Аудитын гол асуудал**

Материаллаг буруу эрсдэлийн үнэлгээ өндөр анхаарал татах асуудал гараагүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

**Монгол Алтайн нурууны улсын тусгай хамгаалалттай газруудын хамгаалалтын захиргааны  
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>38217778.00</u></b>	<b><u>39520778.00</u></b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	38217778.00	39520778.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	38217778.00	39520778.00
35410	Бичиг хэргийн материал	0.00	44000.00
35420	Аж ахуйн материал	1234400.00	1234400.00
35430	Сэлбэг хэрэгсэл	69500.00	914500.00
35440	Түлш, шатах тослох материал	210000.00	624000.00
35470	Бусад хангамжийн материал	36703878.00	36703878.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>232112220.43</u></b>	<b><u>185034558.16</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	232112220.43	185034558.16
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	142103661.43	95025999.16
39201	Барилга, байгууламж, орон сууц	105510526.05	105510526.05
39202	Хуримтлагдсан элэгдэл	-14997980.52	-19997307.57
39203	Авто-тээврийн хэрэгсэл	131885430.00	131885430.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-96503429.96	-131885430.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	43096895.03	43096895.03
39206	Хуримтлагдсан элэгдэл	-31929755.06	-36877028.61
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	9493614.40	9493614.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	-5758965.13	-7179301.14
39209	Зам, гүүрийн байгууламж	842400.00	842400.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-842400.00	-842400.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	704412.34	704412.34
39215	Хуримтлагдсан элэгдэл	-375686.72	-704412.34
39217	Ном	978601.00	978601.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	90008559.00	90008559.00
39301	Програм хангамж	550000.00	550000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-550000.00	-550000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	90008559.00	90008559.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>270329998.43</u></b>	<b><u>224555336.16</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>270329998.43</u></b>	<b><u>224555336.16</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	270329998.43	224555336.16
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	222757639.00	222757639.00
51101	Өмч: - төрийн	222757639.00	222757639.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-30227506.54	-76002168.81
51210	Өмнөх үеийн үр дүн	8298102.58	-30227506.54
51220	Тайлант үеийн үр дүн	-38525609.12	-45774662.27

Монгол Алтайн нурууны улсын тусгай хамгаалалттай газруудын хамгаалалтын захиргааны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	77799865.97	77799865.97
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>270329998.43</b>	<b>224555336.16</b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

			<b>Төгрөгөөр</b>	
<b>Дансны код</b>	<b>Үзүүлэлт</b>	<b>Өмнөх оны гүйцэтгэл</b>	<b>Тайлант оны гүйцэтгэл</b>	
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>422,768,259.00</b>	<b>414,289,081.00</b>	
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>9,369,259.00</b>	<b>69,938,021.00</b>	
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	9,369,259.00	69,938,021.00	
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	9,369,259.00	69,938,021.00	
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,741,259.00	9,788,242.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	9,335.00	
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,628,000.00	60,140,444.00	
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>413,399,000.00</b>	<b>344,351,060.00</b>	
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	409,899,000.00	331,598,800.00	
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	409,899,000.00	331,598,800.00	
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	3,500,000.00	12,752,260.00	
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	10,000,000.00	
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,500,000.00	1,070,000.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,682,260.00	
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>461,293,868.12</b>	<b>460,063,743.27</b>	
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>461,293,868.12</b>	<b>460,063,743.27</b>	
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	361,790,374.04	435,554,662.07	
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	224,704,597.91	249,090,919.75	
210101	Үндсэн цалин	163,817,500.00	188,876,192.72	
210102	Нэмэгдэл	53,778,732.91	53,343,596.03	
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,108,365.00	6,871,131.00	
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	32,838,000.00	33,476,270.00	
210201	Тэтгэврийн даатгал	23,108,200.00	22,755,200.00	
210202	Тэтгэмжийн даатгал	2,432,400.00	2,680,470.00	
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,946,000.00	1,981,600.00	
210204	Ажилгүйдлийн даатгал	486,500.00	699,000.00	
210205	Эрүүл мэндийн даатгал	4,864,900.00	5,360,000.00	
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	5,021,500.00	7,104,720.00	
210301	Гэрэл, цахилгаан	600,000.00	577,200.00	
210302	Түлш, халаалт	4,421,500.00	6,519,920.00	
210303	Цэвэр, бохир ус	-	7,600.00	

Монгол Алтайн нурууны улсын тусгай хамгаалалттай газруудын хамгаалалтын захиргааны  
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	9,936,215.45	75,894,834.05
210401	Бичиг хэрэг	738,900.00	1,090,044.00
210402	Тээвэр, шатахуун	8,249,730.00	16,749,920.05
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	927,585.45	794,970.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	20,000.00	57,190,900.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	69,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	115,000.00	196,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	50,000.00	196,700.00
210604	Урсгал засвар	65,000.00	-
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	2,575,000.00	5,444,000.00
210702	Дотоод албан томилолт	2,575,000.00	5,444,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	30,688,251.56	17,261,056.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	30,067,051.56	16,639,020.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	187,500.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	79,500.00	12,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	31,500.00	78,876.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	47,700.00	96,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	275,000.00	389,000.00
210807	Газрын төлбөр	-	45,960.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	55,911,809.12	47,086,162.27
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,100,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,000.00	8,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	50,801,809.12	47,077,662.27
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	99,503,494.08	24,509,081.20
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	31,898,741.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	31,898,741.00	-
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	67,604,753.08	24,509,081.20
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	67,604,753.08	24,509,081.20
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(38,525,609.12)</b>	<b>(45,774,662.27)</b>
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-	-
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(38,525,609.12)</b>	<b>(45,774,662.27)</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Монгол Алтайн нурууны улсын тусгай хамгаалалттай газруудын хамгаалалтын захиргааны  
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>421140259.00</b>	<b>354148637.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>7741259.00</b>	<b>9797577.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	7741259.00	9797577.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	7741259.00	9797577.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7741259.00	9788242.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		9335.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>413399000.00</b>	<b>344351060.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	409899000.00	331598800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	409899000.00	331598800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	3500000.00	12752260.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		10000000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3500000.00	1070000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		1682260.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>421140259.00</b>	<b>354148637.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>421140259.00</b>	<b>354148637.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>321636764.92</b>	<b>329639555.80</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	224704597.91	249090919.75
210101	Үндсэн цалин	163817500.00	188876192.72
210102	Нэмэгдэл	53778732.91	53343596.03
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7108365.00	6871131.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	32838000.00	33476270.00
210201	Тэтгэврийн даатгал	23108200.00	22755200.00
210202	Тэтгэмжийн даатгал	2432400.00	2680470.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1946000.00	2144400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	486500.00	536200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4864900.00	5360000.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	5021500.00	7104720.00
210301	Гэрэл, цахилгаан	600000.00	544100.00
210302	Түлш, халаалт	4421500.00	6519920.00
210303	Цэвэр, бохир ус		40700.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	8410115.45	15825870.00
210401	Бичиг хэрэг	207800.00	238000.00
210402	Тээвэр, шатахуун	7177730.00	14714600.00

Монгол Алтайн нурууны улсын тусгай хамгаалалттай газруудын хамгаалалтын захиргааны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	927585.45	794970.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	97000.00	78300.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>35000.00</b>	<b>29000.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	35000.00	29000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>130000.00</b>	<b>135800.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	130000.00	135800.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2359000.00</b>	<b>5012000.00</b>
210702	Дотоод албан томилолт	2359000.00	5012000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>44618551.56</b>	<b>17194116.05</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	44022351.56	16572080.05
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	187500.00	
210803	Даатгалын үйлчилгээ	79500.00	91500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	59400.00	78876.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	19800.00	16700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250000.00	389000.00
210807	Газрын төлбөр		45960.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>3520000.00</b>	<b>1770860.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3500000.00	1682260.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	20000.00	88600.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>99503494.08</b>	<b>24509081.20</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>31898741.00</b>	<b>0.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	31898741.00	
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>67604753.08</b>	<b>24509081.20</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	67604753.08	24509081.20
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	222,757,639.00	77,799,865.97	-30,227,506.54	270,329,998.43
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	222,757,639.00	77,799,865.97	-30,227,506.54	270,329,998.43

Монгол Алтайн нурууны улсын тусгай хамгаалалттай газруудын хамгаалалтын захиргааны  
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	222,757,639.00	77,799,865.97	-30,227,506.54	270,329,998.43
D08	Тайлант үеийн үр дүн			-45,774,662.27	-45,774,662.27
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	222,757,639.00	77,799,865.97	-76,002,168.81	224,555,336.16

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	341748800.00	316887295.80
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	341748800.00	316887295.80
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	341748800.00	316887295.80
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	270308600.00	249090919.75
210101	Үндсэн цалин	189394600.00	188876192.72
210102	Нэмэгдэл	73710300.00	53343596.03
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7203700.00	6871131.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	33788600.00	33476270.00
210201	Тэтгэврийн даатгал	22976200.00	22755200.00
210202	Тэтгэмжийн даатгал	2703100.00	2680470.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2162400.00	2144400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	540700.00	536200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5406200.00	5360000.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	7163600.00	7104720.00
210301	Гэрэл, цахилгаан	544100.00	544100.00
210302	Түлш, халаалт	6549700.00	6519920.00
210303	Цэвэр, бохир ус	69800.00	40700.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	8030000.00	7707870.00
210401	Бичиг хэрэг	242500.00	238000.00
210402	Тээвэр, шатахуун	6596600.00	6596600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1112600.00	794970.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	78300.00	78300.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		
2105	<b>Нормативт зардал</b>	29400.00	29000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	29400.00	29000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	135800.00	135800.00

Монгол Алтайн нурууны улсын тусгай хамгаалалттай газруудын хамгаалалтын захиргааны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210601	Багаж, техник, хэрэгсэл	135800.00	135800.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	2102400.00	2060000.00
210702	Дотоод албан томилолт	2102400.00	2060000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	20101800.00	17194116.05
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19477700.00	16572080.05
210803	Даатгалын үйлчилгээ	91500.00	91500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	80000.00	78876.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	16700.00	16700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	389000.00	389000.00
210807	Газрын төлбөр	46900.00	45960.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	88600.00	88600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	88600.00	88600.00
<b>13</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	341748800.00	316887295.80
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	331598800.00	307089718.80
131001	Улсын төсвөөс санхүүжих	331598800.00	307089718.80
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	10150000.00	9797577.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10000000.00	9788242.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	150000.00	9335.00
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	24.00	24.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	17.00	17.00
620003	Үйлчлэх ажилтан	3.00	3.00
620004	Гэрээт ажилтан	3.00	3.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>24.0</b>	<b>24.0</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	18.00	18.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	3.00	3.00
650010	Гэрээт ажилтан	3.00	3.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

			Төгрөгөөр
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>3500000.00</b>	<b>12752260.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3500000.00</b>	<b>12752260.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	3500000.00	12752260.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	0.00	8118000.00

Монгол Алтайн нурууны улсын тусгай хамгаалалттай газруудын хамгаалалтын захиргааны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210402	Тээвэр, шатахуун		8118000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	0.00	2952000.00
210702	Дотоод албан томилолт		2952000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	3500000.00	1682260.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3500000.00	1682260.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	3500000.00	12752260.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	3500000.00	12752260.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		10000000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3500000.00	1070000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		1682260.00

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

##### Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Монгол Алтайн нурууны байгалийн бүс бүслүүрийн онцлог, өвөрмөц тогтоц, байгалийн харьцангуй унаган төрхөөрөө байгаа үзэсгэлэнт хэв шинжийг хадгалах, ховор ховордсон ургамал, амьтан, цэвэр усны нөөц, түүх соёлын үл хөдлөх дурсгал бүхий газар нутгийг улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамруулах замаар хувьсан өөрчлөгдөх зүй тогтлыг судлан таньж мэдэх, сөрөг нөлөөллийг бууруулах, зүй бус ашиглалтаас сэргийлж, хүний амьдрах таатай орчныг бүрдүүлж хойч үедээ өвлүүлэн үлдээхэд оршино.

Хамгаалалтын захиргааны чиг үүрэг

- Тусгай хамгаалалттай газар нутгийн талаарх төрийн бодлого хууль тогтоомж, тухайн газар нутгийн хамгаалалтын горимын биелэлтийг хангуулах
- Тусгай хамгаалалттай газар нутгийн үнэт зүйлс, биологийн төрөл зүйлийг судлах, хамгаалах, урьдчилан сэргийлэх, менежментийн болон бизнесийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, хяналт тавих ажлыг зохион байгуулах, сурталчлах.
- Уламжлалт зан үйл, уул овоо тахих, бусад ёслол үйлдэх ажлыг зохицуулах
- Зөвшөөрөгдсөн бүсэд аялал, жуулчлалын зам, чиглэлийг тэмдэгжүүлэх, газрыг уламжлалт мал аж ахуйн нөөц даацад үндэслэн зөв зохистой ашиглуулах
- Нутгийн иргэдэд түшиглэсэн байгаль хамгааллын бодлогыг холбогдох бүх талуудтай түншийн харилцаа тогтоох замаар хэрэгжүүлнэ.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

##### Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Монгол Алтайн нурууны улсын тусгай хамгаалалттай газруудын хамгаалалтын захиргаа нь Монгол Улсын үндсэн хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Ашиг сонирхлын зөрчлийн тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх үнэлгээний тухай, Газрын тухай хууль, Хөрс хамгаалах цөлжилтөөс сэргийлэх тухай, Иргэдийн өргөдөл гомдлын тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Нийтийн албанд нийтийн

Монгол Алтайн нурууны улсын тусгай хамгаалалттай газруудын хамгаалалтын захиргааны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Байгууллагын хөтөлбөл зохих нягтлан бодох бүртгэлийг холбогдох заавар журмын дагуу хөтөлж, бараа материалын тайланг гаргаж, цалингийн цэсэд хавсаргах холбогдох тушаал, шийдвэр болон санхүүгийн анхан шатны баримтуудыг зохих журмаар бүрдүүлсэн байна.

Монгол Алтайн нурууны улсын тусгай хамгаалалттай газруудын хамгаалалтын захиргаа нь 2022 онд шалгалтад хамрагдаагүй тул дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Монгол Алтайн нурууны улсын тусгай хамгаалалттай газруудын хамгаалалтын захиргаа нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### **Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар**

Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн А/641 тоот тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн бүртгэлийн бодлогын баримт бичгийг ажилдаа мөрдлөг болгодог байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Монгол Алтайн нурууны улсын тусгай хамгаалалттай газруудын хамгаалалтын захиргаа нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 44.6 сая төгрөгөөр буюу 3.8 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

Монгол Алтайн нурууны улсын тусгай хамгаалалттай газруудын хамгаалалтын захиргааны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага			
Бараа материал	38,217.8	39,520.8	1,303.0
Үндсэн хөрөнгө	232,112.2	185,034.6	-47,077.6
<b>Нийт хөрөнгө</b>	<b>270,329.9</b>	<b>224,555.3</b>	<b>-45,774.6</b>
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	270,329.9	224,555.3	-45,774.6
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>270,329.9</b>	<b>224,555.3</b>	<b>-45,774.6</b>

Мөнгөн хөрөнгө, авлага, өр төлбөр дансанд өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гараагүй бол бараа материалын дансанд бага дүнтэй, үндсэн хөрөнгийн дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Бараа материалын данс 1.3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь бичиг хэрэг, сэлбэг хэрэгсэл, түлш, шатах тослох материалын үлдэгдэл нэмэгдсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс 47.1 сая төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгөд 47.1 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Тайлант оны үр дүнгээр Засгийн газрын хувь оролцоо данс 45.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр зарлагын нийт дүнг 574.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас төсвийн төслийг хянаж, төсвийн төслийн саналаас цалин хөлс болон нэмэгдэл урамшлыг 40.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 6.2 сая төгрөгөөр нэмэгдэж, хангамж, бараа материалын зардлыг 35.2 сая төгрөгөөр, нормативт зардал 9.6 сая төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 8.1 сая төгрөгөөр, томилолт, зочны зардал 21.1 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 22.4 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 0.4 сая төгрөгөөр бууруулж нийт 232.3 сая төгрөгөөр бууруулж ба 341.7 сая төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 341.7 сая төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 331.6 сая төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагааны орлогоос 9.8 сая төгрөг оруулсан байна.

Монгол Алтайн нурууны улсын тусгай хамгаалалттай газруудын хамгаалалтын захиргааны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 316.8 сая төгрөг буюу 92.7 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 24.8 сая төгрөгөөр дутуу зарцуулж, жилийн эцэст улсын төсөвт 24.5 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. Өөрийн орлогоос 10.1 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 9.8 сая төгрөг оруулж, 0.3 сая төгрөгөөр тасарсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	341.7	316.8	-24.9	92.7%
	<b>Дүн</b>	<b>341.7</b>	<b>316.8</b>	<b>-24.9</b>	<b>92.7%</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр 12.7 сая төгрөг авч үйл ажиллагаанд 100 хувь зарцуулсан байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Монгол Алтайн нурууны улсын тусгай хамгаалалттай газруудын хамгаалалтын захиргаа нь 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Монгол Алтайн нурууны улсын тусгай хамгаалалттай газруудын хамгаалалтын захиргаа нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Нурлан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Монгол Алтайн нурууны улсын тусгай хамгаалалттай газруудын хамгаалалтын захиргааны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Монгол Алтайн нурууны улсын тусгай хамгаалалттай газруудын хамгаалалтын захиргаа нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 09 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Монгол Алтайн нурууны улсын тусгай хамгаалалттай газруудын хамгаалалтын захиргаа нь 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагын 9.2 сая төгрөгөөс 2 хувиар буюу 7.4 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор цалин хөлс болон нэмэгдэл урамшлыг 21.2 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 0.3 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хангамж, бараа материалын зардал, нормативт зардал, томилолт, зочны зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж зардлуудыг 3.3 сая төгрөгөөр нийтдээ 24.8 сая төгрөгөөр хэмнэлттэй зарцуулсан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад “Төрийн хэмнэлтийн тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангаж ажилласан ба алдаа, зөрчил илрээгүй.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Тайлант онд Шилэн дансны мэдээллээс шалгах программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгав.

Тайлант онд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээний 1 мэдээллийг хугацаанд мэдээлсэн бол төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой нийт 11 тушаал, шийдвэр гарснаас 7 мэдээллийг хугацаанд,

Монгол Алтайн нурууны улсын тусгай хамгаалалттай газруудын хамгаалалтын захиргааны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

21.9 сая төгрөгийн 4 шийдвэрийн мэдээллийг орхигдуулсан, шилэн дансны хуулийн хэрэгжилт 89 хувьтай байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын дүнгээр зөвлөмж өгөгдлөө.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар алдаа, зөрчил илэрээгүй тул нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна.

#### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Бусад хууль тогтоомжийн хүрээнд алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Завсрын аудит хийгдээгүй.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж, албан шаардлага өгөгдөөгүй байна.

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Германы Олон улсын хамтын ажиллагааны GIZ /Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох/ төслийн шугамаар 2022 оны 08 дугаар сард Ланд-76 маркын авто машиныг хүлээн авч ашиглаж байгаа боловч Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас төрийн өмчид бүртгэх талаар зохих шийдвэргүй гараагүй байгаа учраас үндсэн хөрөнгийн данс бүртгэлд тусгахгүй байх чиглэл өгсний дагуу орлогод аваагүй байгаа асуудлыг дараагийн аудитаар анхаарч үзэх шаардлагатай.

### **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

---

Аудитаар санхүүгийн тайлантай холбоотой алдаа илрээгүй, залруулга хийгдээгүй.

Аудитаар нийт 23.3 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 0.5 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 0.9 сая төгрөгийн албан шаардлага, 21.9 сая төгрөгийн зөвлөмж хүргүүлсэн.

Хууль хяналтын байгууллагад албан шаардлагаар шилжүүлсэн, хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлсэн асуудал байхгүй.

#### **5.1 Төлбөрийн акт**

1. Тус газрын дарга нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2022 оны 12 дугаар сарын Б/89 дүгээр урамшуулал олгох тухай тушаалаар 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдөр 502.0 мянган төгрөгийн урамшуулал, 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/23 тоот тушаалаар 5,558.8 мянган төгрөгийн урамшуулал олгох тушаал гаргаж, гүйцэтгэлээр 6.071.8 мянган төгрөг буюу 513.0 мянган төгрөгийн урамшууллыг төсвөөс илүү авсан байна.

## **5.2 Албан шаардлага**

1.Томилолтын зардалд нийт 5,012.0 мянган төгрөгийг зарцуулснаас гүйцэтгэлийг шалгаж үзэхэд 12 дугаар сарын 15-ны өдөр 244.0 мянган төгрөг, 18-ны өдөр замын зардалд 260.0 мянган төгрөг, 20-ны өдөр 420.0 мянган төгрөгийн, нийтдээ 924.0 мянган төгрөгийн зардлыг анхан шатны бүрдэл дутуу баримтаар төсвөөс зарлага гаргасан байна.

## **5.3 Зөвлөмж**

### ***1. Үндсэн хөрөнгийн ашиглалт, бүртгэлтэй холбоотой асуудал***

#### **1.1. Илрүүлэлт:**

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, цаашид ашиглах боломжгүй болсон 20.4 сая төгрөгийн 12 ширхэг LIFAN-150 маркийн мотоциклийг актлаагүй, цаашид ашиглах боломжтой иж бүрэн 1 ширхэг 7.3 сая төгрөгийн оврын бага оврын тракторын үнийг шинэчлэн тогтоогоогүй байна.

#### **1.2 Өгсөн зөвлөмж:**

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 7 дугаар зүйлийн 7.1 "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох" гэсэн заалтыг мөрдөж, ээлэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн цаашид ашиглах боломжтой үндсэн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоох, цаашид ашиглах боломжгүй болсон 20.4 сая төгрөгийн 12 ширхэг LIFAN-150 маркийн мотоциклийг актлах.

### ***2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал***

#### **1.1. Илрүүлэлт:**

Шилэн дансанд төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 21.9 сая төгрөгийн 4 шийдвэрийг мэдээлээгүй, шилэн дансны мэдээлсэн байдлын хэрэгжилт 89 хувьтай байна.

#### **1.2 Өгсөн зөвлөмж:**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэсэн заалтыг мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Дүн</b>												

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллага д шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаал тны тоо	Тоо	Дүн
Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үндсэн хөрөнгө	1	0					1	0				
Анхан шатны бүрдэл дутуу баримтаар төсвөөс зарлага гаргасан					1	924.0						
Урамшууллыг төсвөөс илүү авсан			1	513.0								
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>513.0</b>	<b>1</b>	<b>924.0</b>	<b>1</b>	<b>0</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой	1	21 934.8					1	21 934.8
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>21 934.8</b>					<b>1</b>	<b>21 934.8</b>
Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>21 934.8</b>					<b>1</b>	<b>21 934.8</b>